

2018.08.31

№

15/133

танай

-ны №

-т

**Анхдагч зах зээлийн арилжааны
хуваарилалтын тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 08 сарын 29-ны өдрийн хуралдаанаар Үнэт цаас гаргагч “Мандал даатгал” ХХК-ийн хувьцааг анхдагч зах зээлд нийтэд санал болгохыг зөвшөөрсөн. Үнэт цаас гаргагч болон андеррайтерийн харилцан тохиролцсоны дагуу анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг авах хугацааг 2018 оны 09 сарын 04-ний өдрөөс эхлэн 2018 оны 09 сарын 18-ны өдрийг дуустал хугацаанд авахаар шийдвэрлэсэн болно. Захиалга авах сүүлийн өдөр буюу 9 сарын 18-нд захиалга оруулах цагийг 15:00 цаг хүртэл сунгах хүсэлттэй байна.

Мөн “Мандал даатгал” ХХК-ийн 1,560,754 ширхэг хувьцааг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 3 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон үнийн аргаар санал болгож 7,491,619,200 төгрөгийг татан төвлөрүүлэхээр ажиллаж байна. Тус хөрөнгийг татан төвлөрүүлэхтэй холбоотой арилжааны захиалгын хэмжээ давсан нөхцөлд суурь хуваарилалт хийх мөнгөн дүнг 1 тэрбум төгрөгөөр тооцон нийт захиалга өгсөн хүний тоонд тэнцүү хуваарилна.

Үлдэгдэл мөнгөн дүн буюу 6,491,619,200 төгрөгийг нийт захиалгын мөнгөн дүнтэй харьцуулан хувь тэнцүүлэн хуваарилна.

Хувийг: Санхүүгийн зохицуулах хороонд;

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.АМАРБАЯСГАЛАН